



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 331

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Барилгын политехник коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 35,000,000.00 (гучин таван сая) төгрөгийн балансын үнэ, 4,200,000.00 (дөрвөн сая хоёр зуун мянган) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан суудлын автомашиныг Өвөрхангай аймгийн Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Өвөрхангай аймгийн Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирал С.Сансар нарт дараах арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
 2018 оны 7 дугаар сарын 23 ны өдрийн
 331 дугаар тогтоолын хавсралт

**"БАРИЛГЫН ПОЛИТЕХНИК" КОЛЛЕЖООС ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН МЭРГЭЖИЛ СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВД
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН**

Д/д	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг
1	Туксон, 6063- УНС, КМНJT81BCDU697354 Суудлын автомашин	2013/2013	86032	35,000,000.00	4,200,000.00	30,800,000.00
НИЙТ ДҮН				35,000,000.00	4,200,000.00	30,800,000.00
				(гучин таван сая төгрөг)	(дөрвөн сая хоёр зуун төгрөг)	(гучин сая найман зуун мянган төгрөг)